

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	15
4.3. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.4. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.5. Аудит хийсэн зорилтот түвшин, гүйцэтгэлийн тайлан	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЭЗҮ	Техник Эдийн Засгийн Үндэслэл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.16 № 06/884
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 27, тусдаа санхүүгийн тайлангийн дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Конфиденсе Аудит” ХХК-ийн П.Ариунаа ахлагчтай баг хариуцаж хэрэгжүүлэв.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 01/490 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрхэм зорилго:

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь Тавантолгой ордын хайгуул, судалгаа болон олборлолт, борлуулалтын үйл ажиллагаа явуулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар ашигт ажиллагааг нэмэгдүүлж, сайн чанарын нүүрсний үндэсний брэнд бүтээгдэхүүн бий болгож олон улсад гаргах, аюулгүй, тогтвортой, хариуцлагатай уул уурхай, аж үйлдвэрийг хөгжүүлэн улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодит хувь нэмрээ оруулж, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгийн үр өгөөжийг хүртээх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Хувьцаат компанийн дүрмээр "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нүүрсний ордын хайгуул, судалгаа, олборлолт, борлуулалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа
- Ложистикийн үйл ажиллагаа, гаалийн хяналтын бүсэд бүтээгдэхүүн хадгалах, ачиж буулгах, тээвэрлэх
- Ордыг ашиглахтай холбоотой боловсруулах үйлдвэр байгуулах, шаардлагатай дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилгоор лабораторийн үйл ажиллагаа эрхлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх.

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн удирдлага дараах хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ "Би Ти солюшн" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Силикон 2.0 болон Силикон 3.0 санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 43 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 38 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 1 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус компани 2017 онд төрийн болон ард түмний хувьцааг санхүүгийн тайландаа бүртгэсэн. Дээрх бүртгэлээс

шалтгаалан балансын дүн 11,182,447.9 сая төгрөгөөр нэмэгдсэн. Иймд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр цэвэр хөрөнгө, нийт хөрөнгийг сонгох нь тохиромжгүй гэж үзэж нийт орлогыг сонгосон.

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн 2019 оны нийт орлого 2,710,804.2 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 27,108.0 сая төгрөгөөр төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан бөгөөд гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг хэвээр үлдээв.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,060,503.72 сая төгрөгөөр өссөн. Материаллаг өөрчлөлт гарсан дансны авлага, урт хугацаат хөрөнгө оруулалт, бусад эргэлтийн бус хөрөнгө, хуримтлагдсан ашиг данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(сая төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	605,258.48	656,360.02	51,101.53
Дансны авлага	49,626.54	222,962.49	173,335.94
Бараа материал	104,110.86	105,541.23	1,430.36
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,725.26	12,334.14	3,608.88
Үндсэн хөрөнгө	31,646.32	37,416.54	5,770.21
Биет бус хөрөнгө	11,184,756.41	11,159,414.52	(25,341.89)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	462.01	312,187.51	311,725.50
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	10,649.41	13,711.91	3,062.49
Хойшлогдсон татварын хөрөнгө	62.63	23,302.07	23,239.43
Бусад эргэлтийн бус хөрөнгө	313,157.06	798,825.10	485,668.04
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,324,641.76	13,385,145.48	1,060,503.72
Богино хугацаат өр төлбөрийн дүн	285,218.37	311,850.96	26,632.59
Урт хугацаат өр төлбөрийн дүн	35,596.47	43,375.88	7,779.41
Хувьцаат	11,196,000.00	11,196,000.00	-
Хуримтлагдсан ашиг	807,826.92	1,833,918.64	1,026,091.72
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,324,641.76	13,385,145.48	1,060,503.72

Дансны авлагын өсөлт нь жилийн эцсээр хийсэн зээлээрх борлуулалтаас шалтгаалжээ.

Урт хугацаат хөрөнгө оруулалт, бусад эргэлтийн бус хөрөнгө өссөн нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөртэй холбоотой олгосон санхүүжилтүүдээс шалтгаалжээ.

Тайлант онд борлуулалтын орлого өссөнөөс хуримтлагдсан ашиг өссөн байна.

2.9. ЗОРИЛТОТ ТҮВШИН, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн 2019 оны борлуулалтын орлогын таамаглал 2,386,264.2 сая төгрөг, үйл ажиллагааны зардлын төсөв 1,291,894.8 сая төгрөг, хөрөнгө оруулалтын төсөв 428,158.2 сая төгрөгөөр батлагджээ.

Компани 2019 онд Цанхийн Баруун уурхайн гэрээт олборлогчийг шалгаруулах тендер амжилтгүй болж, үйл явц удааширснаас үүдэн 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр хүртэлх хугацаанд олборлолтын үйл ажиллагаа зогссон. Үүнээс шалтгаалан уурхайн төлөвлөгөө биелээгүй ч борлуулалтын төлөвлөгөө, улсад төвлөрүүлэх татвар хураамж, цэвэр ашиг гэх мэт бусад эдийн засгийн зорилтод төлөвлөгөөг биелүүлэн ажилласан байна. Гүйцэтгэлийг төсөвтэй харьцуулж үзэхэд борлуулалтын орлогыг 12 хувиар, нийт ашгийг 6 хувиар давуулан биелүүлсэн байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 24 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 19 эрсдэл тодорхойлж нийт 38 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 21,112.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 16,052.3 сая төгрөгийн алдааг залруулж, 2 албан шаардлага хүргүүлж, 5,000.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах залруулагдаагүй алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Хувьцааны бүртгэлтэй холбоотой асуудал нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.1.5, 18 дугаар зүйлийн 18.1. заалтуудтай нийцэхгүй, “үнэн зөв байх”, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Эргэн төлөлт хийгдэхгүй байгаа авлагатай холбоотой асуудал нь Нягтлан бодох бүртгэлийн тухайн хуулийн 12.1. заалттай нийцэхгүй, “эрх ба үүрэг”, “оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

Аудитаар илэрсэн 5,000.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Залруулсан алдааны талаарх тодруулга:

2019 оны санхүүгийн тайланд нийт 16,052.3 сая төгрөгийн 21 залруулга хийсэн. Эдгээр залруулгуудыг хураангуйлан харуулбал доорх байдалтай байна. Үүнд:

1. Хугацаатай хадгаламжийн хүүг 2019.12.31-нээр хуримтлуулан бүртгэхтэй холбоотой 1,137.3 сая төгрөг,

2. Нөхөн сэргээлтийн нөөцийн өөрчлөлттэй холбоотой бараа материалын өртөг нэмэгдсэн 2,972.0 сая төгрөг,

3. 2019 оноос өмнө гарсан IPO-тэй холбоотой зардлыг хуримтлагдсан ашиг руу хаасан бичилт 781.3 сая төгрөг,

4. 2019 онд гарсан IPO-тэй холбоотой зардлын ангилал өөрчлөн бүртгэсэн 1,727.9 сая төгрөг,

5. 2019 онд гарсан IPO-тэй холбоотой зардлыг тайлант үеийн зардалд бүртгэсэн 1,469.8 сая төгрөг,

6. Барааны өртөг дахин тооцож борлуулсан бүтээгдэхүүний өртөг буурсантай холбоотой 3,810.9 сая төгрөг,

7. Залруулга хийсэнтэй холбоотой орлогын албан татварыг дахин тооцоолж бүртгэсэн 640.9 сая төгрөгийн залруулга хийв.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг авч үзнэ. Үүнд:

- 2011 онд бичигдсэн ТЭЗҮ-д хөрс хуулалт болон нүүрс олборлолтын харьцааг үе шат болгонд гаргаж өгсөн. Энэ харьцаагаар хөрс хуулалтын хөрөнгийг зардалд системтэйгээр шингээхийн тулд илүү хуулсан хөрс хуулалтыг хойшлуулж биет хөрөнгөөр бүртгэдэг. ТЭЗҮ-д шинэчлэлт хийгдээгүй, одоогийн байдлаар ТЭЗҮ-ийг баримталж уулын ажлыг явуулаагүй боловч ТЭЗҮ-д заасан хувиар хөрс хуулалтын хөрөнгийг бүртгэж нүүрсний өртөгт шингээж байгаа. 2019 онд гэрээ хийж ТЭЗҮ болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлүүлэхээр олон улсын зөвлөх компани сонгон ажиллаж байна. Зөвлөх компаниас ирсэн зөвлөмжийн дагуу бүртгэлд өөрчлөлт орсон асуудал;

- Зүүн цанхийн олборлогч Ти Ти Жэй Ви Си Өү ХХК болон “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хооронд байгуулсан гэрээнд “Үнэ цэний өсөлт бууралт”-ыг хагас жил тутамд тооцоолж алдагдал хүлээсэн талдаа төлбөр төлөхөөр тусгасан. Бид гэрээний дүн нь ам.доллараар батлагдсан боловч үнэ цэний өсөлт бууралтын тооцооллыг хийж байгаа нь буруу гэж үзэн, олон улсын байгууллагаар энэ асуудлыг шийдвэрлүүлэхийг зөвлөж ирсэн зэрэг асуудлуудад анхаарал хандуулах;

- Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст “Тавантолгой” ХК нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн мөргөцгийн хил давж 268.0 мянган тонн нүүрс олборлосон гэх гомдол мэдээлэл шалгагдаж байгаа, хэрхэн шийдвэрлэснийг хянах;

- “Эрдэнэс-Тавантолгой” ХК-аас охин компаниуд болон улсын бүтээн байгуулалтад оруулсан хөрөнгө оруулалтын үр өгөөж, эргэн төлөлт, хэрэгжилтийн явцад гүйцэтгэлийн аудит хийх талаар санал оруулах шаардлагатай гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Эрдэнэс-Тавантолгой” ХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК Шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хуудсанд байршуулах 7 төрлийн 62 мэдээллийг бүрэн байршуулсан байна. Тайлант онд цахим санд жилд нэг удаа оруулах 2 мэдээ, сар бүр оруулах 60 мэдээллийг хугацаанд нь оруулсан.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлсэн бөгөөд хэрэгжүүлэх шатанд ажиллаж байна. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

"Прайсуотерхаускуперс аудит" ХХК-тай 2019 оны 12 дугаар сард ЭТТ-2019/860 тоот Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт хийх "Зөвлөх үйлчилгээний гэрээ" байгуулан хамтран ажиллаж байна. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн 2015 оноос 2019 оныг дуустал ашиглаж байгаа нүүрсний өртгийн бодлогыг судалж үзээд Олон

улсын стандартад нийцэж байна гэсэн эхний дүгнэлт гарсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ нүүрсний өртгийн бодлогын талаар тусгуулахаар ажиллаж байна.

2. ТЭЗҮ-ийн тодотголын талаар

ТЭЗҮ-ийн тодотгол, шинэчлэлийн ажлыг гүйцэтгэхээр “Эм Эм Маркет” ХХК-тай 2019 оны 09 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байна.

Нийт 13 зөвлөмж өгснөөс 12 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд буюу зөвлөмжийн хэрэгжилт 89 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 27, Тусдаа Санхүүгийн Тайлангийн дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Ажилчидтай холбоотой шүүхийн зарга маргаантай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Тус байгууллагад өнөөгийн байдлаар иргэн, захиргааны маргаантай 20 асуудал байна. Үүний 10 нь ажилчдыг ажлаас халсан, албан тушаал өөрчилсөн маргаан байна. 2019 онд үндэслэлгүй ажлаас халсан гэсэн шүүхийн шийдвэрээр 4 хүнд 54.5 сая төгрөг, байгууллагын хариуцах нийгмийн даатгалд 5.5 сая төгрөг, нийт 60.0 сая төгрөгөөр байгууллага хохирсон байна.

3.1.2. Эрсдэл:

Төрийн буюу нийтийн өмчид хохирол учрах

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Ажилчдыг ажлаас халах, бүтцийн өөрчлөлт хийхдээ алдаа гаргахгүйн тулд хуулийн хэлтсийхэнтэй хэрхэн хамтран ажиллах талаар бодлого боловсруулах шаардлагатай байна.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Нийгмийн хариуцлагын хүрээнд олгосон санхүүжилттэй холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Нийгмийн хариуцлагын хүрээнд гэсэн тодотголын дор 2018 онд 531.0 сая төгрөг, 2019 онд 6,274.5 сая төгрөгийг зарцуулснаас Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 08 дугаар захирамж, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 154 дүгээр тогтоолын 3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны

4 дүгээр сарын 17-ны өдрийн 18 дугаар тэмдэглэлийн 2 дахь заалт, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 41 дүгээр тогтоол, 2019 оны 46 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Азийн хүүхдүүд 2020” олон улсын спорт наадмын ажлын хүрээнд 5,000.0 сая төгрөгийг “Улаанбаатар спорт менежмент” ХК-д төлсөн. Компанийн дотоод хяналтын тайлангаас харахад уг хөрөнгө оруулалт нь үр ашиггүй зарцуулагдсан байх магадлалтай байна.

3.2.2. Эрсдэл:

Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байх.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Нийгмийн хариуцлагын хүрээнд төлж байгаа төлбөрийг бөөн дүнгээр аль болох төлөхгүй байх, төлбөрийг ажил гүйцэтгэх гэрээнд нь үндэслэн уг ажлыг гүйцэтгэх нэгжид нь шууд төлөх зэрэг арга хэмжээ авч ажиллахыг зөвлөж байна.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 6 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12 - р сарын 31	2019 оны 12 - р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	605,258,483,115.02	656,360,016,783.45
1.1.2	Дансны авлага	49,626,543,289.34	222,962,485,334.10
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	65,686,144.78	539,420,897.07
1.1.4	Бусад авлага	402,557,437.93	26,834,546,936.22
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	15,325,989,041.03	15,323,473,972.58
1.1.6	Бараа материал	104,110,861,900.76	105,541,226,765.63
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,725,262,029.81	12,334,137,985.70
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	392,534,246.50	392,534,246.50
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	783,907,917,205.17	1,040,287,842,921.25
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	31,646,323,042.66	37,416,536,446.07
1.2.2	Биет бус хөрөнгө	11,184,756,406,143.10	11,159,414,518,191.40
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	462,009,157.49	312,187,509,157.49
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	10,649,413,859.75	13,711,907,860.88
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	62,632,515.73	23,302,067,511.01
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	313,157,059,730.01	798,825,099,315.37
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,540,733,844,448.70	12,344,857,638,482.20
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,324,641,761,653.90	13,385,145,481,403.50
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	94,022,780,176.11	184,098,780,006.11
2.1.1.2	Цалингийн өглөг	6,586,867,856.68	8,862,983,853.85
2.1.1.3	Татварын өр	67,551,892,688.09	88,455,571,781.26
2.1.1.4	НДШ–ийн өглөг	83,279,468.64	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	106,941,522,718.73	23,630,475,928.64

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	10,032,029,336.60	6,803,147,064.20
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	285,218,372,244.84	311,850,958,634.06
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	31,808,479,597.23	36,602,486,605.33
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	3,787,986,607.85	6,773,392,535.29
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	35,596,466,205.08	43,375,879,140.62
2.2	Өр төлбөрийн нийт дүн	320,814,838,449.92	355,226,837,774.68
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн		
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат	11,196,000,000,000.00	11,196,000,000,000.00
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	807,826,923,203.94	1,833,918,643,628.80
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	12,003,826,923,203.90	13,029,918,643,628.80
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,324,641,761,653.90	13,385,145,481,403.50

4.2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12 - р сарын 31	2019 оны 12 - р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,986,874,104,288.29	2,660,970,560,945.28
2	Борлуулалтын өртөг	680,578,288,303.93	695,657,580,691.40
3	Нийт ашиг(алдагдал)	1,306,295,815,984.37	1,965,312,980,253.88
4	Түрээсийн орлого	77,885,426.57	106,145,454.43
5	Хүүгийн орлого	4,038,235,063.30	27,509,403,793.63
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	21,132,405,048.80	7,011,028,207.29
9	Борлуулалт, маркетингийн зардал	278,690,232,113.50	351,069,037,477.24
10	Ерөнхий ба удирдлагын зардал	16,640,425,130.82	19,605,067,376.24
11	Санхүүгийн зардал	4,587,765,729.62	-
12	Бусад зардал	28,723,295,782.68	239,569,180,628.91
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	28,877,715,918.49	16,341,295,876.79
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(65,894,929.61)	(57,092,920.37)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,031,714,443,755.30	1,405,980,475,183.26
19	Орлогын татварын зардал	224,152,246,749.85	370,405,680,110.04
20	Татварын дараах ашиг (алдагдал)	807,562,197,005.46	1,035,574,795,073.22
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	807,562,197,005.46	1,035,574,795,073.22
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000,000,000.00	36,820,605,840.75	11,232,820,605,840.70
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(36,555,879,642.27)	(36,555,879,642.27)
3	Залруулсан үлдэгдэл			
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)		807,562,197,005.46	807,562,197,005.46
5	Бусад дэлгэрэнгүй орлого			
6	Өмчид гарсан өөрчлөлт			
7	Зарласан ногдол ашиг			
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
9	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000,000,000.00	807,826,923,203.94	12,003,826,923,203.90
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(9,483,074,648.35)	(9,483,074,648.35)
11	Залруулсан үлдэгдэл			
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		1,035,574,795,073.22	1,035,574,795,073.22
13	Бусад дэлгэрэнгүй орлого			
14	Өмчид гарсан өөрчлөлт			
15	Зарласан ногдол ашиг			
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
17	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000,000,000.00	1,833,918,643,628.80	13,029,918,643,628.80

4.4. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12 - р сарын 31	2019 оны 12 - р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,748,187,478,071.33	2,479,132,362,016.53
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,705,463,601,128.00	2,390,054,698,305.28
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	47,220,621.06	38,567,428.80
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	42,676,656,322.27	89,039,096,282.45
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(983,289,742,759.21)	(1,690,340,468,047.62)
1.2.1	Ажиллагчдад төлсөн	(22,424,325,556.73)	(41,787,153,211.09)
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(6,686,011,766.24)	(11,122,300,000.00)
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	(400,823,015,474.00)	(822,185,520,652.46)
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	(37,366,915.05)	(22,564,096.05)
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(1,608,547,982.91)	(2,876,883,969.56)
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	(98,370,442,285.03)	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	(391,975,591,890.17)	(696,821,669,271.50)
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	(197,012,531.38)	(109,633,550.63)
1.2.9	Бусад мөнгөн зарлага	(61,167,428,357.70)	(115,414,743,296.33)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	764,897,735,312.12	788,791,893,968.91
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,027,911,277.56	26,402,408,276.77
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	4,027,911,277.56	26,402,408,276.77
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(41,992,091,079.55)	(316,598,554,496.50)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(6,175,308,040.85)	(3,266,894,009.00)
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(1,916,783,038.70)	(1,606,160,487.50)
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	(311,725,500,000.00)

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	(33,900,000,000.00)	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(37,964,179,801.99)	(290,196,146,219.73)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(239,664,870,000.00)	(468,768,360,000.00)
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	(239,664,870,000.00)	(468,768,360,000.00)
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(239,664,870,000.00)	(468,768,360,000.00)
4	Валютын ханшийн зөрүү	29,588,571,111.07	21,274,145,919.25
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	516,857,256,621.20	51,101,533,668.43
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	88,401,226,493.82	605,258,483,115.02
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	605,258,483,115.02	656,360,016,783.45

4.5. Аудит хийсэн зорилтот түвшин, гүйцэтгэлийн тайлан
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Д/д	ҮЗҮҮЛЭЛТ	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүн	Хувь
1	Борлуулалтын орлого	2,386,264,233,931.93	2,660,961,190,197.45	274,696,956,265.53	112%
2	Борлуулах нүүрсний хэмжээ /тонн/	15,497,624.45	15,497,624.45	-	100%
3	Үйл ажиллагааны зардал	1,291,894,880,265.58	1,298,257,104,388.53	6,362,224,122.94	100%
4	Үйлдвэрлэлийн зардал	937,297,306,391.80	926,176,267,155.25	(11,121,039,236.55)	99%
5	Удирдлагын зардал	21,843,714,009.73	19,605,067,376.24	(2,238,646,633.49)	90%
6	Борлуулалт, маркетингийн зардал	331,342,259,864.05	351,069,037,477.24	19,726,777,613.19	106%
7	Хайгуул ба үнэлгээний зардал	1,411,600,000.00	1,406,732,379.79	(4,867,620.21)	100%
8	Үйл ажиллагааны бус зардал	11,084,124,500.00	7,781,651,929.51	(3,302,472,570.49)	70%
9	Үйл ажиллагааны бус зардал	5,056,915,500.00	1,507,124,662.80	(3,549,790,837.20)	30%
10	Нийгмийн хариуцлагын зардал	6,027,209,000.00	6,274,527,266.71	247,318,266.71	104%
11	Бусад зардал	-	246,664,999,275.78	246,664,999,275.78	-
12	Бараа материалын үнийн бууралт	-	11,294,474,546.34	11,294,474,546.34	-
13	Найдваргүй авлагын зардал	-	60,326,400.44	60,326,400.44	-
14	Хүү торгууль хөнгөлөлтийн зардал	-	409,834,575.00	409,834,575.00	-
15	Урт хугацаат авлагын үнэ цэнийн бууралт	-	218,616,160,797.57	218,616,160,797.57	-
16	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз +, гарз-	-	(57,092,920.37)	(57,092,920.37)	-
17	Ханшийн алдагдал -, ашиг+	-	16,341,295,876.79	16,341,295,876.79	-
18	Улсын төсөвт төвлөрүүлэх татвар	634,034,633,238.47	735,449,742,869.84	101,415,109,631.37	116%

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2020/11/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын	Эрдэнэс-Тавантолгой ХК		сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Хувьцааны бүртгэлийн талаар		Албан шаардлага өгөх	Стратеги, хөгжлийн газар хариуцсан дэд захирал	Т.Цогтбаяр
2	Эргэн төлөлт хийгдэхгүй байгаа авлагатай холбоотой асуудал		Албан шаардлага өгөх	Хууль зүйн газар хариуцсан дэд захирал	Ц.Амартүвшин
3	Ажилчидтай холбоотой шүүхийн зарга маргаантай холбоотой асуудал	60.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий удирдлагын хариуцсан дэд захирал	Д.Энхболд
4	Нийгмийн хариуцлагын хүрээнд олгосон санхүүжилттэй холбоотой асуудал	5,000.0	Зөвлөмж өгөх	Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал	Х.Нурлат
Дүн		5,060.0			



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 03 дугаар сарын 25 № 02/190
САГ- 20 20/11/СТА-ТӨЧГ

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. “Эрдэнэс монгол” ХХК-нд олгосон, 2018 оны 6 дугаар сар хүртэл хуримтлагдсан 61,442.4 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй;

2. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 132 дугаар тогтоол, “Эрдэнэс монгол” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК-иудын ТУЗ-ийн тогтоол, шийдвэрүүдийн дагуу “Эрдэнэс монгол” ХХК батлан дааж 2018 оны 6 дугаар сард “Зээлийн санхүүжилт олгох тухай гэрээ”-г байгуулж, тус компаниас олгосон дараах зээлүүдийн гэрээнд заасан эргэн төлөгдөх хугацаа дууссан боловч төлөгдөөгүй, авлага барагдаагүй байна. Үүнд:

- “Шивээ овоо” ХК-д олгосон, 2019 оны 12 дугаар сард зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу бүрэн төлөгдөж дууссан байх жилийн 2 хувийн хүүтэй 1,400.0 сая төгрөгийн зээл;
- “Багануур” ХК-д олгосон, 2019 оны 6 дугаар сард зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу бүрэн төлөгдөж дууссан байх жилийн 2 хувийн хүүтэй 13,900.0 сая төгрөгийн зээл.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 гэсэн заалт болон “Зээлийн санхүүжилт олгох тухай гэрээ”-ний холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх компаниудын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулах талаар холбогдох арга хэмжээ авч, авлагыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх.
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, Хууль зүйн газар хариуцсан дэд захирал Ц.Амартүвшин нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.Наранчимэг
Ц.НАРАНЧИМЭГ
И.Эрдэнэцэцэг
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
АУДИТОР
КОНФИДЕНСЭ АУДИТ ХХК-ИЙН БАГИЙН
АХЛАГЧ *П.Ариунаа*
П.АРИУНАА

TAVAN

ЗӨВШӨӨРСӨН:

“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.Ганхуяг
Б.ГАНХУЯГ
ХУУЛЬ ЗҮЙН ГАЗАР ХАРИУЦСАН ДЭД
ЗАХИРАЛ
Ц.АМАРТҮВШИН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25

№ 02/191

Улаанбаатар хот

СЭГ - 20 20/11/СТА - ТӨМГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- “Эрдэнэс-Тавантолгой” ХК нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154-р тогтоолын 8.2-т заасны дагуу 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайланд биет бус хөрөнгө болон хувьцааг 11,196,000.0 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрсөн, 2018-2019 онуудад биет бус хөрөнгийг элэгдүүлж 43,009.6 сая төгрөгөөр өртөгт шингээж татвар тооцоолох суурьт нөлөөлүүлсэн, хувьцааны үнэ цэнийн тооцооллыг нотлох баримт байхгүй.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 5.1.5-д “хэмжигдэхүйц байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хувьцааны үнэ цэнийг дахин үнэлүүлж, санхүүгийн тайланд залруулга хийх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 12 дугаар сарын 31-нд багтаан Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, ерөнхий нягтлан бодогч Д.Алтанцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
П.АРИУНАА

ЗӨВШӨӨРСӨН:

“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ГАНХУЯГ
ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ
Д.АЛТАНЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

